


—

Кэймёнг Их Сургуулийн Дунсан эмнэлэг

## Эрүүл мэндийн үзлэгийн хөтөлбөр

Эрүүл мэндийн үзлэг нь төрөл бүрийн шинжилгээгээр өвчнийг анхан шатанд нь оношилж амьдралын хэв маягаас үүдэлтэй эрсдэлт хүчин зүйлсийг эрт үед нь илрүүлж өвчлөлийн явцаас урьдчилан сэргийлэхэд суурилана.

Кэймёнг Их сургуулийн Эрүүл мэндийн үзлэгийн төв нь тав тух, таатай орчинд орчин үеийн шинжилгээний тоног төхөөрөмж, мэргэжлийн эмч, мэргэжилтэний зөв оновчтой оношилгоо, өндөр зэрэглэлийн үзлэг үйлчилгээ үзүүлж байна.

Кэймёнг Их сургуулийн Дунсан эмнэлгийн Эрүүл мэндийн үзлэгийн төв нь таны эрүүл мэндийн төлөө насан туршид тань үйлчлэхэд бэлэн байна.

### Кэймёнг Их сургуулийн Дунсан эмнэлэгийн байршил




42601 Дэгү хот Далсо дүүрэг Далгүбол гудамж 1035
[6 давхар Эрүүл мэндийг дэмжих төв]
Төв утас TEL : 1577-6622

**Эрүүл мэндийг дэмжих төв**
TEL : 053-258-5000 FAX : 053-258-6470

**Цаг товлолт, Зөвлөгөө** :
Ажлын өдөр 08:00~17:00 цаг/
Бямба гариг(2, 4 дэх долоо хоног) 08:00~12:00 цаг

**Олон улсын Эрүүл мэндийн төв**
+82-53-258-4007 (Орос хэл, Монгол хэл) / +82-53-258-4004 (Англи хэл)
**Холбоо барих, зөвлөгөө** : Ажлын өдөр 08:30~17:30 цаг

계명대학교 동산병원
KEIMYUNG UNIVERSITY DONGSAN HOSPITAL

нүүр хуудас VR эмнэлэгээр аялах

# Эрүүл мэндийг дэмжих төв

계명대학교 동산병원
KEIMYUNG UNIVERSITY DONGSAN HOSPITAL

Эрүүл мэндийг дэмжих төв Эрүүл мэндийн үзлэгийн хөтөлбөр

## Ерөнхий шинжилгээ

20~40 насны хүмүүст зориулсан гол эрхтнүүдийн үйл ажиллагааны оношилгоо, насанд хүрэгчдийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилготой ерөнхий болон зайлшгүй шаардлагатай шинжилгээнүүд багтсан хөтөлбөр.

| Ангилал | Шинжилгээний төрөл | Төлбөр(вон) |
|---|---|---|
| Ерөнхий шинжилгээ | Биеийн жин, өндөр, даралт, цусны даралт, биеийн жинг иин индекс | Эр 60<br>Эм 65 |
| Нүдний шинжилгээ | Нүдний хараа, нүдний угийн зураг, нүдний даралт | |
| Сонсголын шинжилгээ | Сонсголын ерөнхий шинжилгээ | |
| Зүрхний шинжилгээ | Зүрхний цахилгаан бичлэг (EKG) | |
| Үүшигны шинжилгээ | Үүшигны үйл ажиллагааны шинжилгээ | |
| Цээжний зураг | Цээжний рентген зураг | |
| Ходоодны шинжилгээ | Ходоодны дуран (Нойрсуулагч нэмэлт үнэ төлбөртэй) | |
| Хэвлийн шинжилгээ | Хэвлийн ЭХО | |
| Цусны шинжилгээ | Цусны ерөнхий шинжилгээ | |
| | Гиперлипитеми / цусан дахь өөх тос ихсэх / шинжилгээ | |
| | Электролит, Иммунологи шинжилгээ | |
| | A·B·C элэгний үрэвсэл, элэгний үйл ажиллагааны шинжилгээ | |
| | Бамбай булчирхай, бөөрний үйл ажиллагааны шинжилгээ | |
| | Чихрийн шижин (цусан дахь сахар, глюкозижсон гемоглобин) | |
| | Инсулины эсэргүүцлийн тест | |
| | Хавдрын маркерууд (элэг, бүдүүн гэдэс, нойр булчирхай) | |
| | Витамин Д, Шээсний хүчлийн шинжилгээ | |
| Шээсний шинжилгээ | Цусны улаан бөөм, цусны цагаан бөөм, үураг | |
| Өтгөний шинжилгээ | Өтгөний далд цусны шинжилгээ | |

| Хүйс | Шинжилгээний төрөл |
|---|---|
| Эр | Хавдрын маркер(Түрүү булчирхай) |
| Эм | Хавдрын маркер (ROMA score өндгөвчний хорт хавдрын нарийн шинжилгээ 2 төрөл) Умайн хүзүүний эсийн шинжилгээ, Хөхний рентген зураг |

※ Эмнэлгийн нөхцөлөөс шалтгаалан төлбөрт өөрчлөлт орж болзошгүй.

## Нэмэлт шинжилгээ/Сонголт

Таны нас мэргэжил, хүрээлэн буй орчиноос үүдэлтэй таны санааг зовоож буй зовиур байдаг бол дараахь шинжилгээнүүдээс нэмэлтээр шинжилгээ хийлгэж болно.

| Төрөл | Шинжилгээний төрөл(Үндсэн шинжилгээ багтсан) |
|---|---|
| Зүрх судасны систем | Тархи(MRI&MRA), Титэм судасны CT, Зүрхний ЭХО, Гүрээний артерийн судасны ЭХО , Артерийн судасны хатууралын хэмжээ, Стрессийн шинжилгээ |
| Тархи | Тархины(MRI&MRA), Гүрээний артерийн судасны ЭХО, Артерийн судасны хатууралын хэмжээ |
| Зөнөх өвчиний Танин мэдэхүйн тест | Тархи(MRI&MRA), Зөнөх өвчиний танин мэдэхүйн шинжилгээ PET-CT, Гүрээний артерийн судасны ЭХО, hs-CRP Артерийн судасны хатууралын хэмжээ |
| Зүрх | Титэм судасны CT, Зүрхний ЭХО, Гүрээний артерийн судасны ЭХО, Артерийн судасны хатууралын хэмжээ, Стрессийн шинжилгээ |
| Хоол боловсруулах эрхтэн | Хэвлийн CT, Бүдүүн гэдэсний дуран (унтуулгатай), Хелликобактерийн шинжилгээ, эмчилгээний эмийн жор бичиж өгөх, Early tech бүдүүн гэдэсний хорт хавдрын туслах оношилогооны шинжилгээ |



## VIP Үзлэг

Тав тух, таатай орчинд орчин үеийн тоног төхөөрөмжтийн тусламжтайгаар зөв оновчтой оношилгоо тогтоож, мэргэжлийн эмч мэргэжилтэний нарийн чадварлаг эмчилгээ үйлчилгээ үзүүлдэг өндөр зэрэглэлийн нэгдсэн үзлэг хөтөлбөр юм.

### Fast Track System хэрэгжүүлэх

Мэргэжлийн эмч мэргэжилтэн орчин үеийн төхөөрөмжөөр түргэн шуурхай найдвартай шинжилгээ, оношилгоог хийнэ.

### Тасаг тус бүрийн VIP ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Мэргэжлийн эмч, мэргэжилтэний үзлэг болон тухайн үзлэг үзсэн эмч мэс ажилбар хийнэ.

### Шинжилгээний хариу, зөвлөгөө

VIP тасгийн профессор нь шинжилгээ хийлгэсэн өдөр шинжилгээний хариуг тайлбарлаж зөвлөгөө өгнө.

### Хорт хавдрын генийн шинжилгээ: Myriad myRisk

MYRIAD myRisk® Hereditary Cancer

MyRisk бол 35 төрлийн генийн шинжилгээ гээр 8 төрлийн генийн хорт хавдраар өвчлөх эрсдэлийг илрүүлэх шинжилгээ юм.




※ 1:1 онцгойлон зөвлөгөө өгөх
※ Шим тэжээлийн зөвлөгөө
(Мэргэжлийн шим тэжээл судлаач эмч өдөр тутмын хоолны үнэлгээ хийн үйлчлүүлэгчид тохирсон эрүүл хоолоор хангана)